





ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт





ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **+6.1%**
Инфляци: 2020 онд: **7.5%**

Урсгал тэнцэл: 2020 онд: **-13%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **+6.3%**
Инфляци: 2020 онд: **+7.1%**


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: **-10.8%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 1-р сарын байдлаар 67.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 2.6 хувиар, зарлага 14.9 хувиар тус тус нэмэгдсэн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 49.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 67.2 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 17 төгрөгөөр өсөв.

Нэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 94.7 төгрөг буюу 3.6 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 17 төгрөг буюу 0.6 хувиар, өмнөх улирлаас 2.4 хувиар өсч 2744.38 төгрөг болов. 1-р сард гадаад валютын нөөц 4 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 0.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар, оны эхнээс 13.1 хувиар тус тус өсөв.




Инфляцийн түвшин 6.4%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 1-р сарын байдлаар өмнөх сараас 1.2 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар, оны эхнээс 2.1 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа, хувцас, бөс бараа, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний өссөн нь голлон нөлөөлжээ.




Гадаад худалдааны тэнцэл 14.3 сая.ам доллар болов.

2020 оны нэгдүгээр сард нийт барааны эргэлт 923.3 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 24.4, импорт өмнөх оны мөн үеэс 6 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 14.3 сая ам.долларын ашигтай гарчээ.



1-Р САРЫН ОНЦЛОХ: МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР

Эх сурвалж: www.mongolbank.mn

2019 оны дөрөвдүгээр улирлын байдлаар Засгийн газрын нийт гадаад өр 7.7 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 30.6 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 4% (327,7 сая ам.доллар)-иар өссөн бол, Улсын нийт гадаад өр 2% (744,1 сая ам.доллар)-иар өссөн байна. Харин төв банкны өр 2% буюу 36 сая ам.доллараар өссөн бол хадгаламжийн байгууллагуудын өр 3% буюу 68,7 сая ам.доллараар буурчээ. Нийт гадаад өрийн 25%-ийг засгийн газрын өр, 6%-ийг Төв банкны өр, 7%-ийг хадгаламжийн байгууллагуудын өр, 28%-ийг бусад салбаруудын өр, 34%-ийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ

НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН БҮТЭЭГДЭХҮҮН 4470 АМ.ДОЛЛАРТ ХҮРЭВ.

- Монгол Улсын ДНБ 2019 онд 6.3 хувиар өсөж, нэг хүнд ногдох дотоодын бүтээгдэхүүн 4470 ам.долларт хүрэв. Энэ үзүүлэлтээр манай улс 193 орноос 126 дугаарт эрэмбэлэгдэж байна. Дэлхийн улс орнуудын ДНБ-ний жагсаалтаар тэргүүлэх 10 орноор АНУ, БНХАУ, Япон, Герман, Энэтхэг, Их Британи, Итали, Бразил, Канад, БНСУ, ОХУ эрэмбэлэгдсэн байна. Эдийн засгийн тэргүүлэгч 10 орон дэлхийн ДНБ-ний 66 хувийг эзэлж байна. Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн өсөлт 2018 онд 6.3 хувь байсан бол өнгөрсөн 2019 онд 5.8 хувь, 2020 онд 5.7 хувь, 2021 онд 5.6 хувь болж саарах төлөвтэй байна.

“АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН 2020” ҮР ДҮН ТАНИЛЦУУЛАВ.

- Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс 8 дахь жилдээ боловсруулан гаргаад буй “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2020” үр дүн танилцуулав. Судалгааны үр дүнгээр Орхон аймаг тэргүүлсэн хэвээр байна. Удаах байранд Өмнөговь, Дорноговь, Дархан-Уул аймаг багтжээ. Сүүлийн байруудад Говь-Алтай, Архангай, Булган аймгууд оржээ. Судалгааны үндсэн 4 бүлэг болох: эдийн засгийн тамир тэнхээний үзүүлэлтээр Өмнөговь аймаг, засаглалын үр ашгаар Сүхбаатар, бизнесийн үр ашгаар Дархан-Уул, дэд бүтцээр Орхон аймгууд тус тус тэргүүлжээ.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 1-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 1-р сар 2020 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn